

the USA and its firm interest. The father of the school of realistic theory of foreign policy and international relations, famous American scholar Hans Morgentow said "The foreign policy of the USA has one God. It is the national interests of the USA". These teachings of him are being implemented into life today.

II. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХ

**МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦАА БА
ФРАНКСИЙН Д.РУЗВЕЛЫТ**

*Академич Ч.Далай
ШУА, Олон Улс Судлалын Хүрээлэн*

XX зууны эхэн үед эзэн Чингисийн удмын монголчууд ялангуяа эзэн Чингисийн мэндэлсэн, улс байгуулсан унаган нутгийн гал голомтыг сахиж буй ар монголчуудад түүхийн нэн хариуцлагатай үе тулгарч, бас зовлон зүдүүрч нүүрлэсэн байв. Монголчуудын сэтгэл санаа, зориг хүслийг огтхон ч ойлгодоггүй гадны зарим хүмүүс монголчуудыг бараг л сөнөсөн мэтээр ойлгож, бичиж байсан үе юм. Гэвч монголчууд сөнөөгүй. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцэж байсан. Тэр тэмцэлдээ тусалж чадах гадны хүч эрч хайж байсан. Түүний нэг нь алс холын Америк ч байсан байх гэж бодном. Тийм эгзэгтэй цаг мөчид монголчууд бидний хувьд улаан, цагаанаар ялгах нь гол биш угсаа үндсээ сэргээх нь амин чухал болсон цаг мөч байлаа. Ингээд л 1921 оны хувьсгал хийж туурга тусгай улс болж 1924 онд Бүгд Найрамдах улсыг тунхагласан. Яг тийм үед өмнөд их хөрш Гоминданы хятад монголын эсрэг зүйл бүрийн ил далд ажиллагаа явуулж Монголыг өөрийн хэсэг гэж үзээд түүнийгээ дэлхий дахинд баталгаажуулах гэж тэмцэж байв.

Энэ л тухайн үеийн Монгол Хятадын харилцааны эгзэгтэй, ээдрээтэй асуудал болж байсан юм.

Тухайн үед БНМАУ-ын эргэн тойронд Хятадаас тусгаарлах гэсэн тэмцэл их болсон байв. 30-аад оны эхээр Өвөр Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж түр засгийн газраа ч байгуулж байв. Шинжаанд дорнод Туркстаны улс байгуулагдаж сүүлдээ дарагдав. Төвдөд ч тусгаарлах хөдөлгөөн өрнөв. Яг ийм нөхцөлд монголын тусгаар тогтнолын асуудал аяндаа дэлхий дахины шинж чанартай болж ирсэн юм.

Дундад иргэн улс ч мөчөөгөө өгөхгүй монголын тусгаар

тогтнолын эсрэг янз бүрийн ажиллагаа шил дараалан явуулсаар байв.

1929 оны 7-р сарын 11-нд яамны эрх хэмжээтэй нүсэр том байгууллага "Монгол Төвдийн хороо"-г байгуулав. Манай улсын баяр наадмын өдөр 7-р сарын 11-ийг сонгон авч хороо байгуулсан нь аанаа Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэсэн хэрэг байлаа. 1931 оны 5-р сард Наньжинд "Монголын хурал" гэгчийг хуралдуулав. Тэнд Өвөр Монгол, Төвдөөс олон төлөөлөгч оролцуулж, монгол, төвд үндэстэн түүхээс Хятадын хэсэг байсан гэж сурталчилгаа явуулав. Монгол, Төвдийн хорооны хийх гол ажил байлаа.

Гоминданы намын анхдугаар хурлыг хуралдуулж монгол аймаг хошуудын зохион байгуулалтын хууль гэгчийг батлан гаргав. Монгол улсын баруун хилийн ойролцоо Хятадын цэргийн том анги байрлаж манай улсыг алхам тутам харж судалж байв. Тэр армид олон жил ажилласан генерал Чжан Дацзюнь одоо Тайваньд байгаа бөгөөд "гадаад Монголын шинэ үеийн түүх" гэдэг олон боть сонирхолтой ном бичив.

Ийм хүнд нөхцөлд Монголчууд бид тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд баталгаажуулах, НУБ-ын гишүүн болох явдал байв. Одоо өөрийн мэдэх Америк, өөрийн мэдэх Ф.Рузвельтийн талаар сэтгэгдлээ бичье. Би 1940 онд хөдөө нутагт бага сургуульд орсон. Тэр үед Америк гэдэг нэр дуулснаас өөрцгүй байсан. 1944 онд Х.А.Уэльс Монголд ирсний дараа манай багш нар тэр Америк орон чинь дэлхийн ядуучуудад тусалдаг улс гэнэ. Манай Монголд туслах юм гэнэ. Хоёр Монголыг нэгтгэж өгөх юм гэнэ гэх мэтээр баяр хөөр болон ярьж байсан санагддаг юм.

Одоо би О.Латтиморын надад хэлж өгсөн Америк орон, ерөнхийлөгч Рузвельтын тухай тэмдэглэлээсээ авч ярьв.

1971 онд Латтиморын хэлж байсан зүйлээс:

-Та нар Америк улсыг ойлгохгүй байна. Яагаад гэвэл их буруу сурталчилгаа явуулж байснаас юм. Америк улс бага буурай оронд тусалдаг, дэмжлэг үзүүлдэг. Гацхүү түүнд үргэлж Америкийн эрх ашиг оршиж байдаг юм.

-Танай улсын хувьд Америкийн дэмжлэг олохгүйгээр НУБ-ын гишүүн болоход хэцүү байсан. Танай улсын далбаа НУБ-ын байранд мандахад би их баярласан. Дилба хутагт их уйлсан.

Ч.Далай

"Монгол-Хятадын харилцаа ба Франклин Д.Рузвельт"

АЛТАН АРГАМЖ

91

-Нэг үе Америкчууд танай монголчуудыг огт ойлгодоггүй, мэддэггүй байсан. Харин Чингисийн монгол гэхээр ухаардаг.

-Танай монгол улс хэзээ нэг цагт Америкийн тусламжийг олно. Америкаас битгий айтгүн.

-Рузвельт ерөнхийлөгч бол их ухаалаг, хүн чанартай хүн байсан. Америкт дөрвөн удаа сонгогдсон ерөнхийлөгч байхгүй. Надаас Монголын тухай их юм асуудаг байсан. Тэр үед би танай Монгол улсын байдлыг сайн мэдэхгүй тул гүйцэд үнэн зүйл ярьж өгч байгаагүй. Гэхдээ Монголын талаар явуулж буй Хятадын бодлогыг үнэн мөнөөр нь ярьж өгдөг байсан.

-Рузвельт ерөнхийлөгч 1933 онд Зөвлөлт улстай дипломат харилцаа тогтоосон явдал хүйтэн дайныг зайлуулахад их ашигтай зүйл болсон. Америк Зөвлөлт Орос улс хоёр дипломат харилцаатай болсон нь танай улсын хувьд их ашигтай болсон.

-Америкийн дэд ерөнхийлөгч Уэльсыг дагалдаж 1944 оны 7-р сарын 2-нд танай улсад ирж хоёр хоногсон. Бид их сайн сэтгэгдэлтэй явцаасан. Ямар ч гэсэн тусгаар улс болох суурь тавьжээ гэдэг сэтгэгдэл төрсөн. Тэр үед хамгийн эрх дархтай нь маршал Чойбалсан, Оросын элчин сайд Иванов хоёр л байх шиг харагдсан.

-Уэльс дэд ерөнхийлөгч бид Монгол улсын их сургууль үзээд сэтгэл хөдөлсөн. Ямар ч гэсэн үндэсний их сургуультай болжээ. Энэ бол улс үндэстэн сэргэхийн билэг тэмдэг гэж бид үзсэн.

-Бид очоод Рузвельт ерөнхийлөгчтэй уулзсан. Рузвельт-монгол тусгаар улс болох хэмжээнд хүрсэн байна уу? гэж асуухад Латтимор хүрэхээр барах уу, тэр улс чинь өндийсөн байна гэхэд дэргэдээс нь Уэльс яг тийм гэж хэлсэн.

Хариуд нь Рузвельт улс болох үндэс суурь нь тавигдсан бол түүнийг хөгжүүлэхэд амархан гэж хэлсэн юм. Тэгээд Рузвельт дахин асуусан нь: тэр гадаад Монгол улс чинь Чингисийн уг гал голомт мөн үү?

Латтимор: Яг Чингисийн төрсөн нутаг, газар шороо нь мөн гэж хариулжээ.

Рузвельт дэхин өвөр, ар хоёр монголын чинь аль нь монголын гол хэсэг вэ? Тэр хоёр нэгдэж чөдөх уу гэж асуухад Латтимор дэлгэрэнгүй тайлбар хэлж өгчээ.

Ф.Д.Рузвельт ийнхүү Монголын талаар зохих мэдлэгтэй

Ч.Далай

"Монгол-Хятадын харилцаа ба Франклин Д.Рузвельт"

болжээ. Ингээд 1945 оны 2-р сарын 4-12 хүртэл болсон Крымын хэлэлцээрээр Монголын тусгаар тогтнолыг Зөвлөлт Орос, Америк Англи гурван улсын тэргүүн зөвшөөрч гарын үсэг зурахад Рузвельт ерөнхийлөгч их үүрэг гүйцэтгэжээ.

Эцэст нь дүгнэхэд:

Франклин Делано Рузвельт (1882-1945) Америкийн ерөнхийлөгч 1933-1945 он хүртэл 12 жил хийсэн, 4 удаа сонгогдсон төрийн том зүтгэлтэн юм. Тэрээр их ч мэдлэг боловсролтой, ухаантай, хүн чанартай том зүтгэлтэн байжээ. Монголчууд Рузвельт ерөнхийлөгчийн ач тусыг мартаж болохгүй билээ. Монголын ард түмний дотор хамгийн өндөр нэр хүнд олсон ерөнхийлөгч бол Рузвельт мөн билээ.

МОНГОЛ, АМЕРИКИЙН ХАРИЛЦАА: XX ЗУУНЫ ЭХЭН ХАГАСТ

МУИС, ОУХС-ийн багш,
доктор (Ph.D) Д.Уламбаяр

Америкийн капитал-Монголд нэвтэрч эхэлсэн нь

XIX зууны сүүлч XX зууны эхээр Алс Дорнодод Орос, АНУ, Япон, Өрнөдийн их гүрнүүд нөлөөний хүрээгээ цэрэг зэвсэг, эл, далд улс төр, дипломатын аргаар нэгэнтээ хувааж дуусч байлаа. 1899 онд АНУ Хятадад явуулах улс төр, эдийн засгийн цогц "нээлтэй хаалганы" бодлогыг зарлан тунхаглав. Энэхүү номлолыг АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Ж.Хей санаачлан боловсруулж, Конгрессоор батлуулан улмаар 1899 оны есөөс арван нэгдүгээр сард Англи, Герман, Франц, Хаант Орос, Япон, Италийн Засгийн газруудад ноотоор мэдэгджээ. "Нээлттэй хаалганы" бодлогын мөн чанар нь их гүрнүүд Хятадад тэгш эрх эдэлж нэвтрэн ороход оршиж байв.

АНУ Номхон далайн орнуудад газар нутгийн сонирхолтой байсан бөгөөд Чин улс, Хятадын зүгт юуны өмнө худалдаа, эдийн засгийн сонирхол давамгайлж улс төр хоёрдугаарт тавигдаж байлаа. Америк нь бусад их гүрнүүдийн нэгэн адил Хятадын асар

Д.Уламбаяр

"Монгол Америкийн харилцаа XX зууны эхэн хэвцэг"

АЛТАН АРГАМЖ

удам зах зээл, байгалийн баялаг, хямд ажиллах хүч, стратегийн байршилд анхаарлаа хандуулж байв.

1909 оны 12 дугаар сарын 14-нд АНУ, Манжуурын бүх төмөр замыг тухайлбал Дорнод Хятадын төмөр зам, Өмнөд Манжуурын төмөр зам хоёрыг "нийт дундын болгох" тухай төрийн нарийн бичгийн дарга Филандер К.Ноксын төлөвлөгөөг зарласан нь хэрэг дээрээ өөрийн хүчирхэг эдийн засагт түшиглэн, тэндээс Япон, Хаант Оросыг шахаж гаргахад чиглэгдэж байв. Энэ саналыг Хаант Орос, Япон хоёр эс хүлээн авбал АНУ Цзиньчжоу-Айгуныгийн чиглэлээр төмөр зам тавихаар төлөвлөжээ. Ноксын төлөвлөгөөг Мүгдэн дэх АНУ-ын консул Виллард Стрейт улам тодотгон 1909 оны сүүлээр "Манжуур, Монгол болон Оросын Алс Дорнодод" Америкийн эдийн засгийн хяналт тогтоох төлөвлөгөө" боловсруулан энэ асуудлаар Чин улсын Засгийн газартай хэлэлцээр хийж энэ тухайгаа төрийн департаментдээ мэдээлж байжээ.

Манжуур ба Монголын талаар АНУ-ын эл бодлогыг Хаант Орос, Япон хоёр хамтран эсэргүүцэж чадахгүй ахул Алс Дорно зүгт байр сууриа америкчуудад алдаж болох байлаа. Иймээс 1910 оны эхээр Япон, Хаант Орос хоёр Манжуурын төмөр замуудыг "интернационалчлах буюу биеийг нь даалгах" АНУ-ын саналыг олгхон ч зөвшөөрөхгүй гэдгээ албан ёсоор мэдэгджээ. Гэсэн хэдий боловч Америкийн үйлдвэр, худалдааны бүлгийнхэн Хятад дахь ашиг сонирхлоо хэрэгжүүлэх өөр зам хайсан бөгөөд 1910 оны зунас Англи, Франц, Германы компаниудтай нийлж Хунань, Хубэй төмөр зам байгуулах ажилд оролцох болсон байна.

Ийнхүү XIX зууны сүүлчээс АНУ-ын Алс Дорнодын ашиг сонирхол буй болж төрийн бодлогын хэмжээнд хүртэл тавигдаж Монгол ч энэ хүрээнд багтах болсон байна. Ийм дээрээс Чин улс, Хаант Орос, Японы зүгээс баруун Европ, америкийн эдийн засаг, улс төрийн нөлөөг Монголд нэвтрүүлэхгүй хаалттай бүс нутаг байлгаж дангаар эзэмшихийн тулд ил далд төрөл бүрийн арга хэрэглэж байв. Үүний тод жишээ нь Чин улсын Засгийн газраас Монголд явуулж байсан "шинэ засгийн бодлого" гэгч байв. Гэвч Монгол нь хүссэн, хүсээгүй дэлхийн капиталист зах зээлийн хүрээнд улам бүр татагдан орж, европ, америкийн бараа, таваар хятад худалдаачдаар дамжин Монгол газар үзэгдэх

Д.Уламбаяр

"Монгол Америкийн харилцаа XX зууны эхэн хэвцэг"